

## ХУРАЛДААНЫ ТОЙМ

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2014 ОНЫ 33 ДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2014 оны арваннэгдүгээр сарын 20-ны 14 цаг 04 минутад эхэлж, 15 цаг 43 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 39 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай</p> <ul style="list-style-type: none"><li>- Төв аймгийн нутгийн захиргааны байгууллагын сул орон тоог нөхөх</li><li>- Худалдан авах ажиллагааны газар, Жендерийн Үндэсний хорооны сул тоог нөхөх</li></ul>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2014 оны 11 дүгээр сарын 07, 10, 11-ний өдрүүдэд Төв аймагт зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 11 дүгээр сарын 20 - ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. Төв аймагт 2014 оны 11 дүгээр сарын 07, 10, 11-ний өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 78 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 68 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх.</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 3 дугаар</p>

хавсралтад дурдсан нэр бүхий 19 иргэнийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 4 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 10 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар тус тус нэр дэвшүүлэх.

3. Энэхүү тогтоолын 3, 4 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 29 нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Төв аймаг дахь салбар зөвлөл /Д.Нямдорж/-д үүрэг болгох.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2014 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :

1. Худалдан авах ажиллагааны газар, Жендэрийн Үндэсний Хорооны төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн жинхэнэ албаны

		<p>мэргэшлийн шалгалтад тэнцсэн тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 25 иргэнийг “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэх.</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 5 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэх.</p> <p>3. Энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 5 нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тус тусын албан тушаалд томилохыг Жендэрийн Үндэсний Хорооны Ажлын албаны дарга /М.Болормаа/-д, Худалдан авах ажиллагааны газрын дарга /Б.Энхжаргал/-д тус тус үүрэг болгох</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	<p>Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын Шинэтгэлийн бодлого төлөвлөлтийн газрын Мэдээллийн технологи, инновацийн хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гаргуулах тухай</p>	<p>Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Нямбаагийн Энхбатыг Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан харилцаа</p>

		<p>холбооны газрын Шинэтгэлийн бодлого, төлөвлөлтийн газрын Мэдээллийн технологи, инновацын хэлтсийн даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх.</p> <p>2. Энэ тогтоолын 1 дэх хэсэгт нэр заасан иргэн Нямбаагийн Энхбатыг Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан харилцаа холбооны газрын Шинэтгэлийн бодлого, төлөвлөлтийн газрын Мэдээллийн технологи, инновацын хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан харилцаа холбооны газрын дарга Ц.Жадамбаад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гаргуулах тухай</p>	<p>Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Тогтохбаярын Лхагвасүрэн, Чимэддоржийн Нямсайхан нарыг Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх.</p> <p>2. Энэ тогтоолын 1 дэх хэсэгт нэр заасан иргэдээс Тогтохбаярын Лхагвасүрэнг Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Монгол Улсын сайд,</p>

		Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын үүрэг гүйцэтгэгч Ч.Сайханбилэгт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
4	Зарим албан хаагчдад төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгуулах тухай	Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйл, “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг батлах тухай” Улсын Их Хурлын 1995 оны 73 дугаар тогтоолоор баталсан журмын 2, 6 дахь заалт, “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журамд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын 2000 оны 20 дугаар тогтоолын 1-д заасны дагуу төрийн захиргааны албан тушаалын тэргүүн болон эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгуулахаар ирүүлсэн саналыг хэлэлцээд, нэг албан хаагчид тэргүүн түшмэлийн, 17 албан хаагчдад эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгуулах саналыг Засгийн газарт уламжлахаар шийдвэрлэв.
5	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, “Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2014 оны 101 дүгээр тогтоолын 1, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.2, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг”, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн: 1. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дугаар тогтоолын 1 дүгээр

		<p>хавсралтын “Хоёр”-ын 8–д “Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын дэргэдэх төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн” гэснийг “Төрийн албаны зөвлөлийн Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүн” гэж,</p> <p>1) “Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын дарга” гэснийг “Ерөнхий газрын дарга” гэж,</p> <p>2) “Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын тэргүүн дэд дарга” гэснийг “Тэргүүн дэд дарга” гэж,</p> <p>3) “Тамгын хэлтсийн дарга “ гэснийг “Дэд дарга” гэж,</p> <p>4) “Зөвшөөрөл, бүртгэлийн хэлтсийн дарга” гэснийг “Захиргаа удирдлагын газрын дарга гэж,</p> <p>5) “Хуулийн хэлтсийн дарга” гэснийг “Хүний нөөц, сургалтын хэлтсийн дарга” гэж,</p> <p>6) “Хүний нөөц, сургалтын тасгийн дарга” гэснийг “Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсийн дарга” гэж ,</p> <p>7) “Тамгын хэлтсийн Хүний нөөц, сургалтын тасгийн мэргэжилтэн” гэснийг “Хүний нөөц сургалтын хэлтсийн мэргэжилтэн” гэж тус тус өөрчлөх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
6	<p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын Бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай</p>	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.2, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг”, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн</p>

		<p>хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын “Хоёр”-ын 7.“Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн” гэсэн хэсгийн 3-т “Захиргаа, мэдээллийн технологийн асуудал хариуцсан дэд дарга” гэснийг “Хяналт, шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтсийн дарга” гэж өөрчлөх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--	--	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

